



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 14 өдөр

Дугаар 8/101


Мөрөн сум

Байгаль орчин, аялал жуулчлалын  
газрын бүтэц, орон тоог шинэчлэн  
батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.12, 65 дугаар зүйлийн 65.1.8, Захиргааны ерөнхий хуулийн 40 дугаар зүйлийн 40.2, 43 дугаар зүйлийн 43.1, Засгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 377, 2022 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 417 дугаар тогтоол, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2022 оны 08 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын эрхлэх хүрээний хэрэгжүүлэгч агентлаг Байгаль орчин, аялал жуулчлалын газрын бүтэц, орон тооны хязгаарыг хавсралтаар баталсугай.
2. Батлагдсан бүтэц, орон тооны хязгаар, цалингийн санд багтаан ажлын үр дүнг дээшлүүлж, чиг үүргийн давхардлыг арилгаж, зохион байгуулалтын арга хэмжээг авч ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын газар (П.Мөнхжаргал)-т үүрэг болгосугай.
3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2021 оны А/570 тоот захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.
4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Б.Мөнгөн-Эрдэнэ)-д даалгасугай.

ДАРГА



Ш.ИДЭРБАЯСГАЛАН



Аймгийн Засаг даргын 2023 оны  
03 дугаар сарын 14-ны өдрийн  
А/404 дугаар захирамжийн хавсралт

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН  
ГАЗРЫН БҮТЭЦ, ОРОН ТОО

Д/д	Албан тушаалын нэр	Албан тушаалын ангилал		Батлагдсан орон тоо
		Төрийн захиргаа	Төрийн үйлчилгээ	
	Байгаль орчин, аялал жуулчлалын газар			
1	Газрын дарга	1		1
2	Ахлах мэргэжилтэн	1		1
3	Байгаль орчны мэргэжилтэн	4		4
4	Аялал жуулчлалын мэргэжилтэн	3		3
5	Байгаль орчны хяналтын улсын ахлах байцаагч	1		1
6	Байгаль орчны хяналтын улсын байцаагч	2		2
7	Хуулийн зөвлөх, дотоод хяналтын ажилтан		1	1
8	Байгаль хамгаалагч	56		56
9	Архив бичиг хэргийн эрхлэгч		1	1
10	Нягтлан бодогч		1	1
11	Нярав		1	1
12	Жолооч		2	2
	Зохион байгуулалтын нэгж			
	Ойн алба			
13	Албаны дарга	1		1
14	Албаны ахлах мэргэжилтэн	1		1
15	Мэргэжилтэн	2		2
	Гэрээт ажилтан			
16	Байгууллагын сүлжээ, программ хангамж, IT хариуцсан ажилтан		1	1
17	Хээрийн сургалт, мэдээлэл, туршилтын төвийн сахиул		1	1
18	Үйлчлэгч		1	1
19	Жижүүр		2	2
	Нийт			83
	Тайлбар: Төрийн захиргааны 72, төрийн үйлчилгээний 6, гэрээт ажилтан 5 нийт 83 орон тоо			

\_\_\_\_\_оОо\_\_\_\_\_